



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 9 нэрийн 503,364,762.27 (таван зуун гурван сая гурван зуун жаран дөрвөн мянга долоон зуун жаран хоёр төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 25,000,000.00 (хорин таван сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Булган-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



- 132001368

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2021 оны 05 дугаар сарын 20-ны  
өдрийн 55 дугаар тогтоолын хавсралт

**"БУЛГАН-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ  
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

| №                         | Хөрөнгийн нэр                                                          | Ашиг<br>лалтад<br>орсон<br>огноо | Хэм<br>жих<br>нэгж | Тоо<br>хэм<br>жээ | Балансын үнэ,<br>хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                                                                                                 | Шинэчилсэн<br>үнэ (төгрөг)                   | Цаашид<br>ашиглах<br>жил |
|---------------------------|------------------------------------------------------------------------|----------------------------------|--------------------|-------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|--------------------------|
| 1                         | Донг маркийн, 93-23<br>БУА улсын дугаартай,<br>өөрөө буулгагч,         | 2009                             | ш                  | 1                 | 34,425,208.00                                                                                                                                      | 2,800,000.00                                 | 2                        |
| 2                         | Донг маркийн, 93-24<br>БУА улсын дугаартай,<br>өөрөө буулгагч,         | 2009                             | ш                  | 1                 | 34,425,208.00                                                                                                                                      | 2,800,000.00                                 | 2                        |
| 3                         | Донг маркийн, 93-25<br>БУА улсын дугаартай,<br>өөрөө буулгагч,         | 2009                             | ш                  | 1                 | 54,975,536.00                                                                                                                                      | 4,500,000.00                                 | 2                        |
| 4                         | Хуанг ян маркийн, 11-<br>76 БУЛ улсын<br>дугаартай, өөрөө<br>буулгагч, | 2010                             | ш                  | 1                 | 67,090,909.09                                                                                                                                      | 6,000,000.00                                 | 2                        |
| 5                         | Хуанг ян маркийн, 11-<br>81 БУЛ улсын<br>дугаартай, өөрөө<br>буулгагч, | 2010                             | ш                  | 1                 | 67,090,909.09                                                                                                                                      | 6,000,000.00                                 | 2                        |
| 6                         | Хуанг ян маркийн, 11-<br>91 БУЛ улсын<br>дугаартай, өөрөө<br>буулгагч, | 2010                             | ш                  | 1                 | 67,090,909.09                                                                                                                                      | 6,000,000.00                                 | 2                        |
| 7                         | JR135 маркийн, 50-07<br>БУ улсын дугаартай,<br>автогрейдер,            | 2009                             | ш                  | 1                 | 81,225,000.00                                                                                                                                      | 6,000,000.00                                 | 2                        |
| 8                         | YZ12JC маркийн, 50-09<br>БУ улсын дугаартай,<br>доргиурт индүү,        | 2008                             | ш                  | 1                 | 39,456,916.00                                                                                                                                      | 3,000,000.00                                 | 2                        |
| 9                         | WZ30-25 маркийн, 12-<br>59 БУ улсын дугаартай,<br>ачигч,               | 2008                             | ш                  | 1                 | 57,584,167.00                                                                                                                                      | 3,000,000.00                                 | 2                        |
| <b>ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН</b> |                                                                        |                                  |                    |                   | <b>503,364,762.27</b><br>(таван зуун гурван<br>сая гурван зуун<br>жаран дөрвөн<br>мянга долоон зуун<br>жаран хоёр төгрөг<br>хорин долоон<br>мөнгө) | <b>25,000,000.00</b><br>(хорин<br>таван сая) |                          |